

ДҮҮЕЭ САЙДАА ДУРСАХУЙ

3. Эрэндоо*

Миний бие Гадаад явдлын яамны Олон улсын байгууллагын хэлтэст референтээр түр хугацаанд ажиллаад БНЭУ-д суугаа Монгол улсын Элчин сайдын яаманд орчуулагчаар томилогдсон юм. 1960 онд Монгол улсын их сургуулийн Англи хэлний ангийг анх төгссөн 8 хүний нэг нь би байсан. Тэр үед манай улс одоотой адил өргөн гадаад харилцаатай байсангүй. Тухайн үед хөрөнгөтөн гэгдэж байсан орнуудаас ганцхан Энэтхэг улс манай улсыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоогоод байсан юм. Виза авах, халуун оронд явахын өмнө заавал хийлгэх ёстой урьдчилан сэргийлэх тарилга хийлгэж Москвад хэд хоноод 1961 оны 1 дүгээр сарын 3-даар Дели хотод очсон. Бид англи хэл дөрвөн жил заалгасан ч англи хэлтэн байтугай уг хэлээр ярьдаг гадаадын хүмүүстэй цөөхөн учирсан, уг хэлээр бичих, орчуулах дадлага, чадваргүй шахам хүмүүс байсан. Их сургуульд олон улсын харилцаа, дипломатын талын мэдлэг олгох хичээл заагаагүй учраас энэ салбарын талаарх мэдлэг маань Гадаад явдлын яаманд ажилд ороход яамны ажилтан нарын бидэнд уншсан цөөн цагийн лекцийн хэмжээнд л байсан гэж хэлэхэд хилсдэхгүй. Цөөхөн хоногт бидэнд дипломат албаны үндэс, дипломат баримт бичиг, дипломат ёслол гэх зэрэг асуудлаар анхны мэдэгдэхүүн олгох хичээл зааж байсан тэр хүмүүсийг би одоо ч мартдаггүй юм.

Делид суугаа Элчин сайд М. Дүгэрсүрэн гуай нэг ийм л түүхий хүнийг ЭСЯ-ны шинэхэн ажилтнаар хүлээн авсан хэрэг. Анх очсоны дараа Энэтхэг хүмүүсийн өвөрмөц аялагад дасаагүй учир ярьсан зүйлийг ч, радио нэвтрүүлгийг ч ойлгохгүй, сонин хэвлэлийг тоймлох төдий байсан учир эхний үед хэцүүхэн байсан. Гэвч удалгүй нутгийн хүмүүсийн ярианд дасаж ирсэн. Тэр үед ЭСЯ-ны англи хэлтэй ажилтан нар өглөө бүр англи хэлээр хэвлэгддэг гол гол сонины тоймоор сонин уншлага хийдэг байсан нь хэлний мэдлэгээ ахиулах, суугаа орны байдалтай танилцахад их тус дөхөм болсон. Сайд сонин

* Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

уншлага дээр хийсэн миний мэдээллийг анхааралтай сонсож зарим буруу ташаа ойлгосныг залруулж өөрөө нэмж ярьж тайлбарладаг байлаа. Элчин сайд миний хэр хэмжээг сайтар ойлгож байсан. Тиймээс ч эхний үед нэг их шахааж шаардалгүй ажилд аажмаар дасган сургахад их анхаарч байжээ гэж би санадаг. Дүүеэ орос, англи хэлийг маш сайн эзэмшсэн, тал бүрийн өргөн мэдлэгтэй хүн байсан. Тийм ч учраас бидний залууст англи хэлээр нот бичих, нотын хариу өгөх, зарим бичиг баримт орчуулуулах үүрэг өгөөд түүнийг өөрийн биеэр үзэж засаж, зааж сургадаг байсан. Үүний үрээр би ойр зуурын юм бичих, боловсруулах ажилд суралцаж эхэлсэн юм. Гадны Элчин сайд нар, албаны хүмүүстэй уулзахдаа намайг авч ороод өөрөө англиар ярьж, надаар ярианы тэмдэглэл хийлгэдэг байсан нь өөрийн биеэр үлгэрлэн сургаж байсан нэг хэлбэр байжээ. Мөн за чи тэр Элчин сайдын яам руу ингэж ярь, эсвэл тийм Элчин сайдтай намайг уулзуулах тухай ярь гээд дэргэд сууж байгаад яриулдаг. Тэгэхэд нь эхний үед сүрхий бантаж ичиж зовдог байснаа сайн санаж байна. Чухам ийм маягаар намайг ажилд аажмаар дасгаж өөрийн гараар залж, дипломатын цагаан толгойг зааж, таниулсан хүн бол миний анхны Элчин сайд Дүгэрсүрэн гуай билээ. Элчин сайдын яамны орчуулагчаар томилогдож очсон намайг, орчуулагч биш одоо манайд их түгээмэл болоод байгаа олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн ажилтан (Public relations officer) гэж зарлаж, тийм нэрийн хуудас хэвлүүлж өгч байлаа. Энэ нь бусад Элчин сайдын яамд, суугаа орны албан газруудтай илүү өргөн хүрээтэй харилцах боломжийг миний өмнө нээж, ажилд нь зүгшрүүлэх гэсэн бодол байсныг би их л хожим ухаарсан юм. Тэр үед ЭСЯ-д ёслолын арга хэмжээг одоогоос илүү өргөн зохиодог байсан. Чухам эдгээр арга хэмжээн дээр хүмүүстэй танилцаж холбоо харилцаа тогтоох бас ч элдэв мэдээлэл олох бололцоо гардаг бөгөөд түүнийг хэрхэн зөв ашиглах, хэнтэй юу ярих талаар Элчин сайд бидэнд заавар зөвлөлгөө өгдөг байсан.

Монгол улсыг НҮБ-д элсүүлэх асуудал тэр үед бидний анхаарлын төвд байсан нэг чухал асуудал байв. Иймээс улс орноо сурталчлах Энэтхэгийн НҮБ-г дэмжих нийгэмлэг, олон нийтийн байгууллагуудын дэмжлэг тусламжийг авах, улс орноо сурталчлахад түлхүү анхаардаг байсан. 1961 он Ардын хувьсгалын 40 жилийн ойн жил байлаа. Төвөөс орон нутгийн хэвлэл мэдээлэлд тараах, хэвлүүлэх материал нэлээд ирүүлж байв. Бид түүнийг суугаа орны сонин хэвлэлд гаргах талаар хөөцөлдөж, таньж мэдэх болсон зарим сурвалжлагчдаар дамжуулан цөөнгүй материал төвийн болон орон нутгийн сонинд хэвлүүлсэн. Харин би хариуцсан ажлаа гэж ойлгоод, ямар ч судалгаагүй мөн Элчин

сайдтайгаа ярьж зөвлөлгүй орон нутгийн жижиг сажиг сонинд материал хэвлүүлж сурталчилгааны зардлыг хамаагүй зарцууллаа гэж Дүгэрсүрэн сайдаас анх удаа зэмлэл сонсож байж билээ. Тэр үед англи хэл дээр хэвлүүлэх зүйлийг гол төлөв Энэтхэгт хэвлүүлдэг байсан санагдах юм. МОНЦАМЭ-гээс бэлтгэн ирүүлдэг “Өнөөдрийн Монгол” (Mongolia Today) сэтгүүлийг бид Энэтхэгийн коммунист намын “Шинэ Эрин” хэвлэлийн газарт хэвлүүлээд нэг хэсгийг тэндээ тарааж ихэнхийг нааш нь явуулдаг байлаа. Сайд ирүүлсэн материалыг хянаж, зарим зүйлийг өөрийн биеэр орчуулж хэвлүүлдэг байсан. Тухайлбал сэтгүүлийн нэг дугаарт Жуульч Сандагийн зарим үлгэрийг өөрөө орчуулж хэвлүүлсэн юм. Дүгэрсүрэн сайдын даалгавраар би ойн үеэр Энэтхэгт гаргах гэрэл зургийн үзэсгэлэнгийн тайлбар, Монгол улсын төрийн сүлд, далбааны тайлбарыг орчуулсан юм. Сайд тэдгээрийг үзэж хянаад “Чи оролдоод байвал ойр зуурын юм орчуулчих хүн байна” гэж урмын үг хайрлаж байж билээ. Хөдөөнөөс хотод ирсэн юм үзэж нүд тайлаагүй надад тийм түшэгтэй хүний дэргэд анх ажилласан минь ховор аз жавшаан байсан юм. Зөвхөн сайдаас гадна түүний гэргий сайхан зантай, цайлган сэтгэлтэй Наран эгч тэр хоёроос хувцас хунараа тааруулж өмсөх, хоол ундаа идэх уухаас эхлээд багагүй зүйл сурсандаа би баяртай явдаг. Дүүеэ сайд бол биеэ маш цэвэр авч явдаг цэмцгэр, нямбай хүн байсан. Удалгүй Сайд нутаг буцсан, жил гаран болоод би ч дуудагдсан юм. ГЯЯ-ны Боловсон хүчин чамайг Бээжинд суугаа ЭСЯ-нд орчуулагчаар томилох болсон гэж надад хэлсэн. Дүгэрсүрэн сайд тэр үед шинээр бий болсон ГЯЯ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын тушаалд томилогдон ажиллаж байсан. Дүүеэ сайд нэг өдөр надтай уулзаад “Хүүхээ чамайг Бээжинд томилох юм гэж би сонссон. Чи тийшээ яваад яах вэ, би энэ талаар ярья. Мөдхөн Нью-Йоркт явах боломж ч гарч магадгүй шүү дээ. Чи төв аппаратын ажилтай танилцаж туршлагаж байсан нь дээр” гэж хэлсэн юм. Үнэхээр ч би 1965 онд НҮБ-ын дэргэд суугаа БТГ-т ажиллахаар томилогдон очсон. Тэр үед Дүгэрсүрэн гуай ГЯЯ-ны сайд болсон байлаа. Гадаад явдлын яамны сайдын НҮБ-ын чуулганы Ерөнхий хэлэлцүүлэгт хэлэх үг манай төлөөлөгчийн нэг томоохон ажил болдог байлаа. Сайд эхний жил үгээ оросоор хэлсэн. Уг үгийг Цэдэнбал дарга өөрөө үзэж баталсан байсан юм. Түүнээс хойш англи хэл дээр хэлэх болсон. Сайдын хэлэх үгийг бид хамтарч орчуулаад дараа нь Америкийн коммунист намын сонины нэг ажилтан орчуулгыг эцэслэн хянаж өгдөг байсан. Тэр үед өөдтэй олшруулагч машин ч байсангүй, бид ротатор хэмээх тосон барын машин дээр сайдын үгийг шөнөжингөө олшруулж маргааш өглөө нь баахан улаан нүдтэй хүмүүс хуралд очдог байж билээ. Дүгэрсүрэн сайд

хуралд үг хэлэх хүртлээ үгээ дахин дахин хянан нягталж ганц нэг гэлгүй үгийг засаж сольдог байсан. Энэ нь миний Дүгэрсүрэн гуайтай ойр дөт ажилласан хоёр дахь тохиолдол юм.

Дүгэрсүрэн гуай хүнд чанд хатуу шаардлага тавихын хамтаар залуу хүнийг сурган хүмүүжүүлэхэд онцгой анхаарал тавьж, харж ханддаг байсан. Тийм жишээ ярьвал цөөнгүй. Харин тэрхүү зарчимч хатуу шаардлага нь зарим хүнд таалагддаггүй гомдож гонсойх явдал ч гардаг л байсан биз. Гэхдээ миний үеийнхэн дотор Дүүеэ сайдад талархаж, түүнийг гүнээ хүндэтгэн явдаг нь зонхилно гэдэгт би итгэлтэй байна. Албан ажлын үед тавих ёстой шаардлагаа тавиад, амралтын цагт маш энгүүн найрсаг, нөхөрсөг байж чаддаг нь Дүүеэ сайдын нэг онцлог байсан. Би 2001 онд гэр бүлтэйгээ төрсөн нутаг Баянхонгор аймгийн Галуут суманд очоод Үхэгийн рашаанд цөөн хонож байтал нэгэн орой Дүүеэ сайд гэр бүл, хүүхдүүдийн хамтаар тэнд ирсэн юм. Рашааныг хувьчлан авсан хүмүүс засаж янзлаагүй хэдэн байр нь тун ядмагхан болсон байсан. Эхэлж ирсэн бид арай дөнгүүр өрөөнүүдийг авсан учраас сайдынхан нэлээд тав тух муутай нэг хоносон юм. Дүүеэ сайд бид нар шөнө дөл болтол хөөрөлдөж, сайд өөрийн бага насаа дурсан ярьж бид нэг үдшийг сайхан өнгөрөөж билээ. Харин тэгэхэд би тэр тухлаг сайхан уулзалт бидний сүүлчийн удаагийнх болно гэдгийг даан ч гадарлаагүй билээ.

Монгол улс Зэвсэг хураах хорооны гишүүн болсонтой холбогдуулан Женевт БТГ нээх шийдвэр 1969 онд гарч уг төлөөлөгчийн газрыг нээх үүрэг надад ноогдсон. Тэнд мөн Дүүеэ сайдын удирдлагын дор ажиллах завшаан надад дахин тохиосон юм. Тэр үед цөөвтөр гишүүнтэй байсан өндөр нэр хүндтэй тус хорооны гишүүнээр сонгогдсон нь манай улс дэлхийн хамтын нийгэмлэгт байр сууриа баттай эзэлсний бас нэг баталгаа байсан юм. Зэвсэг хураах хороо хавар, намар 2-3 сараар хуралддаг манай төлөөлөгчдийн тэргүүнээр тэр үед Нью-Йоркт Байнгын төлөөлөгчөөр ажиллаж байсан Элчин сайд М.Дүгэрсүрэн, Парисаас Элчин сайд Ж.Банзар, Берлинээс Б.Эрдэнэбилэг, Белградаас Элчин сайд О.Хосбаяр нар ээлжлэн ирдэг байсан. Дүгэрсүрэн сайдыг төлөөлөгчдийн тэргүүнээр хожим Женевт суугаа Байнгын Төлөөлөгчөөр ажиллаж байх хугацаанд манай улс Зэвсэг хураах хороо гэдэг энэхүү нэр хүндтэй байгууллагад ажиллаж зэвсэг хураах асуудлаарх олон улсын хэд хэдэн чухал гэрээ, конвенцийг боловсруулахад идэвхтэй оролцсон юм. Ийнхүү яриа хэлэлцээнд оролцохдоо Дүгэрсүрэн гуай аливаа асуудалд тун соргог хандаж Монгол улсын нэртэй санал санаачлага дэвшүүлэхэд анхаарч байсан билээ. Тухайлбал “Амьсгал боогдуулагч болон бусад төрлийн хорт хий, бактериологийн

зэвсэг хэрэглэхийг хориглосон 1925 оны Женевийн протокол"-ын 45 жилийн ойг тохиолдуулан уг протоколд элсэн орохыг дэлхийн улс оронд хандан уриалах санаачлагыг Зэвсэг хураах хороонд дэвшүүлж улмаар НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулганы тогтоол санаачлан батлуулж байсан. Тогтоолын төслийг бид хамтран бэлдэж байсан. Сайд тогтоол батлагдсан өдөр Нью-Йоркоос утасдаж бидний тогтоол батлагдлаа гэж өчүүхэн надад зориуд хэлж байсан билээ. Энэ төрлийн аюулт зэвсэг дэлгэрэх хандлага газар авч байсан тухайн цаг үед энэ бол цагаа олсон чухал санаачлага байлаа.

НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудын үйл ажиллагаанд үр бүтээлчээр оролцох нь Монгол улсын дипломат харилцааг өргөжүүлэх, нэр хүндийг өндөржүүлэхэд чухал ач холбогдолтойг мэдэрч үүнд онцгой анхаарч, хүмүүсээ тэр зүгт чиглүүлж ажилласан явдал Дүгэрсүрэн сайдын нэг томоохон ололт байсан. Үүний үрээр хөгжиж буй орнуудын ашиг сонирхолд нийцсэн амин чухал асуудлыг дэвшүүлсэн олон тогтоолыг санаачлан НҮБ-ын чуулганаар батлуулснаар манай орон НҮБ-ын идэвхтэй гишүүний нэгэнд тооцогдох болсон билээ.

Монголын ГЯЯ-ны залуу дипломатуудын бүхэл бүтэн үеийг хүмүүжүүлж, Монгол улсын дипломат албаны нэр хүндийг олон улсын түвшинд өргөсөн нь ГЯЯ-ны сайдаар олон жил ажилласан Дүгэрсүрэн гуайн гавъяат үйлс гэж би боддог. Манай улс НҮБ, олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, улс эх орныхоо хөгжилд дэлхийн хамтын нийгэмлэгийн зүгээс дорвитой тусламж дэмжлэг авч ирсэн нь ч Дүгэрсүрэн сайдын нэртэй салшгүй холбоотой билээ.

Үзэл суртлын хатуу хяналтын дор үндэсний ашиг сонирхол бус социалист хамтын нөхөрлөлийн нэгдмэл байр суурь гэдэг хоосон хийрхэлд автаж байсан тэр амаргүй үед Монгол улсынхаа төлөө өөрийн биеийг умартан зүтгэж, хэңээс ч үл эмээн хэлэх үгээ хэлж түүнийхээ төлөө зарим үед нүд үзүүрлэгдэж явсан төрийн түшээ бол Монгол улсын нэрт дипломатч Мангалын Дүгэрсүрэн мөнөөс мөн билээ.